“ИНВЕСКОР ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

2021 оны 10-р сарын 26-ны өдөр № А/04 Улаанбаатар хот

Хоёрдогч өглөгрүү хөрвүүлэх хэлцлийн бүтэц болон нөхцөлд өөрчлөлт оруулах тухай

“Инвескор ББСБ” ХК (“**Компани**” гэх)-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.11 дэх заалт, Компанийн дүрмийн 8.5.11 дэх заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 09 дүгээр сарын 29-нөөс 10 дугаар сарын 26-ны өдөр хүртэл явуулсан эчнээ санал хураалт болон Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Компанийн 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын А/02 тоот шийдвэрээр батлагдсан Компанийн 85%-ийг эзэмшдэг “Эс Ай Би Жэй Капитал” ХХК-аас эргэлтийн хөрөнгийн зориулалтаар авсан зээл болон хуримтлагдсан хүүг хоёрдогч өглөгт хөрвүүлэх хэлцлийн бүтэц болон нөхцөлд Санхүүгийн зохицуулах хорооны зөвлөмжийн дагуу өөрчлөлт оруулсныг баталсугай;
2. Энэхүү шийдвэртэй холбоотойгоор Компанийн 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын А/02 тоот шийдвэрийг хүчингүй болгосугай;
3. Хоёрдогч өглөгрүү шилжүүлэхтэй холбогдуулан шинэчлэгдсэн “Хоёрдогч өглөг”-ийн гэрээг хянаж, батлахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /Б. Анхболд/-д даалгасугай;
4. Энэхүү тогтоолын хүрээнд Санхүүгийн Зохицуулах Хороонд хоёрдогч өглөгийг бүртгүүлэхэд холбогдох шинэчлэгдсэн материалыг бүрдүүлж өгөх, болон бусад шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирал /Д. Баясгалан/-д даалгасугай;
5. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, холбогдох шаардлагатай арга хэмжээг авч ажиллан, ажлын үр дүнг танилцуулахыг Гүйцэтгэх захирал /Д. Баясгалан/-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /А. Энэрэл/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

“ИНВЕСКОР ББСБ” ХК

Б. АНХБОЛД